

САНГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 7 сарын 27 өдөр

№ 264/К93

Улаанбаатар хот

"Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай"

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.5 дахь хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-г нэгдүгээр, "Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам"-ыг хоёрдугаар, "Нэмэлт тусламж, үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэх журам"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг байгууллагын вэб сайт, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр хангах, эмнэлгийн цахим бүртгэл болон санхүүгийн програмд зохих өөрчлөлт хийж хоорондын уялдааг нь сайжруулах арга хэмжээ авахыг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Төрийн болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, тухай бүр шинэчилж байхыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д, мэдээллийн санг үндэслэн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тодорхойлж жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газар (Д.Төмөртоого) нарт тус тус даалгасугай.

4. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусгаж байхыг Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар (Ж.Ганбат), Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газар (Д.Төмөртоого) нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар (Н.Нарангэрэл), Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Баярт) нарт тус тус даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад нэмэлтээр үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам батлах тухай" Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2006 оны 370/387 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11 дугаар тоот тушаалын
нэгдүгээр хавцралт

“Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ”

I. Төлбөртэй тусламж, үйлчилгээний жишиг хэмжээ

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт	Жишиг хэмжээ /төгрөгөөр/	
1	Аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулсан урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх үзлэгийн багцаас хамааран гэрээний үндсэн дээр тодорхойлно	
2	Үйлчлүүлэгч /иргэн, аж ахуй нэгж, байгууллага/-ийн хүсэлтээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	Тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар	
3	Донтолт, архидалт, мансуурлаас үүссэн гэмтэл, хордлогын оношилгоо, эмчилгээ	Тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар	
4	Сайн дурын дархлаажуулалт		
4.1	Хепатит В вирусийн эсрэг вакцин	5,000	
4.2	Хепатит А вирусийн эсрэг вакцин	28,000	
4.3	Балнадын эсрэг вакцин	30,000	
4.4	Сахуу татрангийн эсрэг вакцин	3,000	
4.5	Менингитийн эсрэг вакцин	5,000	
4.6	Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг гуравт вакцин	5,000	
4.7	Шар чичрэгийн эсрэг вакцин	10,000	
4.8	Томуугийн эсрэг вакцин	9,000	
4.9	Хүний хэвийн иммуноглобулин	8,000	
4.10	Стафилококкийн эсрэг иммуноглобулин	50,000	
4.11	Стафилококкийн эсрэг анатоксин	8,000	
4.12	Тарваган тахлын эсрэг вакцин	6,000	
4.13	Боомын эсрэг вакцин	8,500	
4.14	Боомын иммуноглобулин	3,500	
4.15	Галзуугийн иммуноглобулин	35,000	
4.16	Галзуугийн эсрэг вакцин	15,000	
4.17	Хачигт энцефалитын эсрэг вакцин	13,000	
4.18	Хачигт энцефалитын иммуноглобулин	30,000	
4.19	Харшлын аллерген эмчилгээ	100,000	
5	Эрүүл мэндийн даатгалгүй, өөрийн хүсэлтээр шатлал алгассан, эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ авах зардлын төлбөр нь тухайн улирлын болон жилийн дээд хязгаараас хэтэрсэн үйлчлүүлэгчдэд доорх эмнэлгийн тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.		
5.1	Шүдний зарим оношилгоо, эмчилгээ		
5.1.1	Цоорол	Өнгөц	15,000
5.1.2		Дунд	18,000
5.1.3		Гүн	20,000
5.1.4	Зөөлцийн үрэвсэл	1 сурвалжтай	37,000
5.1.5		2 сурвалжтай	60,000
5.1.6		3 сурвалжтай	70,000

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт		Жишиг хэмжээ /төгрөгөөр/
5.1.7	Холбоосын үрэвсэл	1 сурвалжтай	32,000
5.1.8		2 сурвалжтай	44,000
5.1.9		3 сурвалжтай	60,000
5.1.10	Байнгын ломбо тавих	Цемент	5,200
5.1.11		Глассиономер	5,500
5.1.12		Өөрөө хатуурагч хуванцар	6,000
5.1.13		Гэрлээр хатуурагч хуванцар	14,000
5.1.14		Хуучин ломбо авах	3,000
5.1.15		Бүтэн шүдний хөндий нээх	6,000
5.1.16	Түр ломбо	Эмчилгээний жийргэвч	3,000
5.1.17		Тусгаарлах жийргэвч	3,000
5.1.18		Ломбо	2,000
5.1.19	Сувгийн эмчилгээ	Мэдээ алдуулах	2,000
5.1.20		Мышьяк тавих /Хүнцэл/	3,500
5.1.21		Шүдний хөндийг нээх	3,000
5.1.22		Зөөлц авах (1 суваг)	2,500
5.1.23		Суваг өргөсгөх, цэвэрлэх (1 суваг)	2,500
5.1.24		Шүдний сувгийн эм солих (давтан)	2,000
5.1.25		Шүдний суваг ломбодох (1 суваг)	4,000
5.1.26		Сувгийн хуучин ломбо авах (1 суваг)	4,000
5.1.27	Шүдний тойрон эдийн эмчилгээ	Шүдний чулуу цэвэрлэх (1 шүд)	1,500
5.1.28		Буйланд эм тавих, шавхлага хийх (1 удаа)	2,000
5.1.29		Салстын эмчилгээ (1 удаа)	5,000
5.1.30	Амны хөндийн үйлчилгээ	Шүдний хатуу эдэд лак, гель түрхэх	3,500
5.1.31		Шүд цайруулах эмчилгээ /бүрэн/	180,000
5.1.32		Шүдний сувгаар цайруулах эмчилгээ (1 шүд)	50,000
5.1.33		Голонцортой шүд хийх	30,000
5.1.34		Шүдний паалан тавих	28,000
5.1.35		Силант хийх	5,000
5.1.36		Бүх шүдний өнгөлгөө хийх	15,000
5.1.37		Шүдний буйлны эмгэг хөндийг хусаж цэвэрлэх /SRP/ (1 шүд)	3,000
5.1.38	Мэс ажилбар	Хүүхдийн сүүн шүдний металл түр бүрээс (1 шүд)	20,000
5.1.39		Байнгын шүд авах	15,000
5.1.40		Сүүн шүд авах	8,000
5.1.41		Буруу байрлалтай, хүндрэлтэй шүд авч, оёдол тавих	20,000
5.1.42		Саатсан агт араа далд ургалттай	39,000
5.1.43		Хөндлөн байрлалтай шүд авах	80,000
5.1.44		Хэлний хөвч уртасгах	39,000
5.1.45		Салстын уйланхай авах	29,000
5.1.46		Шүдний гаралтай ясны хальсны идээт үрэвсэл нээх	15,000
5.1.47		Буглаа нэвчдээс, хажиг мундас нээх	15,000
5.1.48		Эрүүний ясны хугаралд чиг тавих	40,000
5.1.49		Шүд авсан ором цэвэрлэх	5,000
5.1.50		Гэмтлийн гаралтай шарханд оёдол тавих /шархнаас хамаарч/	25,000
5.1.51		Мэдээ алдуулах	5,000
5.1.52		Шүд авсаны дараах цус тогтоох	5,000
5.1.53		Хагас болон бүрэн мултарсан шүдэнд чиг тавих	38,000
5.1.54		Буйл тайрах	25,000
5.1.55	Алькоголизаци ба хориг хийх	25,000	
5.1.56	Түүшин засах	30,000	
5.1.57	Тулгуур эдийн хагалгаа хийх (1 шүд)	30,000	
5.1.58	Шүдний имплант хийх (1 шүд)	1,300,000	
5.1.59	Шүдний суурийн оройн уйланхай авах	50,000	
5.1.60	Брекет системийн эмчилгээ хийх	480,000	

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт		Жишиг хэмжээ /төгрөгөөр/
5.1.61		Гингвозктомия, Гингвотомия /буйл тайрах, томорсон буйл авах/	15,000
5.1.62		Сиалографи хийх /шүлсний булчирхайн тодотгогч бодис шахаж зураг авах/	35,000
5.1.63	Уян тагнаатай авагддаг шүдэлбэр	1 шүдтэй шүдэлбэр	40,000
5.1.64		2 шүдтэй шүдэлбэр	45,000
5.1.65		3 шүдтэй шүдэлбэр	50,000
5.1.66		4 шүдтэй шүдэлбэр	55,000
5.1.67		5 шүдтэй шүдэлбэр	60,000
5.1.68		6 шүдтэй шүдэлбэр	65,000
5.1.69		7 шүдтэй шүдэлбэр	70,000
5.1.70		8 шүдтэй шүдэлбэр	75,000
5.1.71		9 шүдтэй шүдэлбэр	80,000
5.1.72		10 шүдтэй шүдэлбэр	85,000
5.1.73		11 шүдтэй шүдэлбэр	90,000
5.1.74		12 шүдтэй шүдэлбэр	95,000
5.1.75		13 шүдтэй шүдэлбэр	100,000
5.1.76		14 шүдтэй шүдэлбэр	105,000
5.1.77	Цутгамал	Дээд	300,000
5.1.78	суурьтай авагддаг	Доод	250,000
5.1.79	Авагддаггүй шүдэлбэр	Шаазан бүрээс	300,000
5.1.80		Цутгамал ган бүрээс	100,000
5.1.81		Алт монетон бүрээс (үнэт металлыг хувь хүн гаргана)	100,000
5.1.82		Хуванцар бүрээс	80,000
5.1.83	Шахмал хуванцар суурьтай авагддаг шүдэлбэр	1 шүдтэй шүдэлбэр	18,000
5.1.84		2 шүдтэй шүдэлбэр	21,500
5.1.85		3 шүдтэй шүдэлбэр	25,000
5.1.86		4 шүдтэй шүдэлбэр	28,000
5.1.87		5 шүдтэй шүдэлбэр	31,000
5.1.88		6 шүдтэй шүдэлбэр	34,500
5.1.89		7 шүдтэй шүдэлбэр	37,500
5.1.90		8 шүдтэй шүдэлбэр	41,000
5.1.91		9 шүдтэй шүдэлбэр	44,000
5.1.92		10 шүдтэй шүдэлбэр	47,000
5.1.93		11 шүдтэй шүдэлбэр	50,000
5.1.94		12 шүдтэй шүдэлбэр	54,000
5.1.95		13 шүдтэй шүдэлбэр	57,000
5.1.96		14 шүдтэй шүдэлбэр	60,000
5.1.97		Бүрэн шүдтэй шүдэлбэр	120,000
5.1.98		Согог, гажиг заслын авдаг зэмсэг	Тэлэгч эрэг
5.1.99	Тэлэгч пүрш		5,000
5.1.100	Хуруун пүрш		4,000
5.1.101	Түлхэгч пүрш		5,000
5.1.102	Уруулын нум		6,000
5.1.103	Адамсын дэгээ		3,000
5.1.104	Нүд хэлбэрийн дэгээ		4,000
5.1.105	Цэцгэн дэгээ		3,000
5.1.106	Суман дэгээ		3,000
5.1.107	Зэллэсэн дэгээ		3,000
5.1.108	Суурь ялтас		8,000
5.1.109	Хазалтын налуу		10,000
5.1.110	Хазалтын хавтгай		10,000
5.1.111	Зөөлөн хэв		3,700
5.1.112	Туслах материал		1,000
5.1.113	Толгойн боолт татлага		26,000
5.1.114	Нүүрний маск татлага		40,000
5.1.115	Хөвхөрсон бреккет		3,000
5.1.116	Нэмэлт хэсэгтэй нум		5,000

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт		Жишиг хэмжээ /төгрөгөөр/
5.1.117		Уруулын даравч	3,500
5.1.118		Хацрын хөндийрүүлэгч	3,000
5.1.119		Чулуун загвар	10,000
5.1.120		MRC (гажиг заслын зэмсэг)	150,000
5.1.121		Ялтсан зэмсэг	40,000
5.1.122		Микро имплант	80,000
5.1.123		Онош тогтоох	10,000
5.1.124		Загвар	7,000
5.1.125		Хэв	3,000
5.1.126	Согог, гажиг заслын авагддаггүй зэмсэг	Брекет (ган)	300,000
5.1.127		Банд	7,000
5.1.128		Нум (1 ширхэг)	6,500
5.1.129		Холбогч резин, татлагын резин (1 ширхэг)	2,500
5.1.130		Зай гаргагч резин, металл зай гаргагч (1 ширхэг)	500
5.1.131		Брекет наах (1 ширхэг)	5,000
5.1.132		Брекет систем (металл)	530,000
5.1.133		Брекет систем (шаазан)	760,000
5.1.134	Бусад	Хуванцар тагнай	15,000
5.1.135		Хуванцар буйл	15,000
5.1.136		Хуванцар шүд	4,000
5.1.137		Зөөлөн хэв	10,000
5.1.138		Туслах материал	8,000
5.1.139		Тусгай халбага	10,000
5.1.140		1 шүд нэмэх	15,000
5.1.141		Засвар шүдэлбэр	5,000
5.1.142		Нэмэлт хуванцар суурь хийх (пербазировка)	8,000
6	Иргэн санаатайгаар амь насаа егүүтгэхээр оролдсон тохиолдлын эмнэлгийн тусламж, үйлчилгээ		Тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
7	Даатгал болон төр хариуцдаггүй, шинээр нэвтэрч буй технологийн шинэчлэлт хийгдсэн тусламж, үйлчилгээ		Тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
8	Гоо заслын болон нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ		
8.1	Гоо заслын тусламж, үйлчилгээ		
8.1.1	Сэтэрхий чих оёх (2 тал)		45,000
8.1.2	Чихний дэлдэн засах		120,000
8.1.3	Чих цоолох		10,000
8.1.4	Хамрын хуучин хугарал засах		412,000
8.1.5	Хамар өндөрлөх		250,000
8.1.6	Хамар, чихнээс гадны биет авах		50,000
8.1.7	Нүдний мах хусах		100,000
8.1.8	Наснаас хамааралтай дээд зовхины арьсны илүүдэл авах (блефаро-халазис)		100,000
8.1.9	Доод зовхины урвалт засах		50,000
8.1.10	Нүдэнд давхраа хийх		150,000
8.1.11	Хүүхдэд гоо сайхны зориулалтаар	Нэг тал	60,000
8.1.12	гажиг заслын авагддаг зэмсэг хийх	Хоёр тал	120,000
8.1.13	Хүүхдэд гоо сайхны зориулалтаар гажиг заслын авагддаггүй зэмсэг хийх		850,000
8.1.14	Уруулын сэтэрхий оёх		100,000
8.1.15	Уруулын хөвч гүнзгийрүүлэх		31,000

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт	Жишиг хэмжээ /төгрөгөөр/
8.1.16	Сорви цэгцлэх (1см)	15,000
8.1.17	Сорви засах	23,000
8.1.18	Сорви зөөлрүүлэх тариа хийх	41,000
8.1.19	Үрэвсэлгүй хар, цагаан батга цэвэрлэх	9,000
8.1.20	Нүүрэнд эрүүл ахуйн иллэг хийх	10,000
8.1.21	Арьсны хоргүй хавдар, үү, мэргийг цахилгаанаар түлж авах (Электрокоагуляци эмчилгээ) /жижиг хэмжээтэй/	10,000
8.1.22	Арьсны хоргүй хавдар, үү, мэргийг цахилгаанаар түлж авах (Электрокоагуляци эмчилгээ) /том хэмжээтэй/	19,000
8.1.23	Арьсны хоргүй хавдар, үү, мэнгэ авах (CO2 лазер) /том хэмжээтэй 1 ширхэг/	15,000
8.1.24	Арьсны хоргүй хавдар авах (CO2 лазер) /их хэмжээний/	70,000
8.1.25	Хөлдөөх эмчилгээгээр үү эмчлэх (1 ширхэг)	5,000
8.1.26	Нүүрний нөсөөт толбо, шивээс арилгах лазер эмчилгээ (Lentigo)	90,000
8.1.27	Батганы сорвины лазер	75,000
8.1.28	Өргөссөн судасны лазер эмчилгээ (бага хэмжээтэй)	35,000
8.1.29	Өргөссөн судасны лазер эмчилгээ (дунд хэмжээтэй)	75,000
8.1.30	Өргөссөн судасны лазер эмчилгээ (их хэмжээтэй)	120,000
8.1.31	RF (Арьс залуужуулах, чангалах массажны аппарат) 1 удаа	37,000
8.1.32	Дааврын тарилга эмчилгээ (Голомтот үс халцрал, зангилаат маажуур, келойд сорви) 1 удаа	17,000
8.1.33	Ялтас эсээр баяжуулсан сийвэн тарих эмчилгээ /нэг удаа/ (PRP)	256,000
8.1.34	Сорил гадаад 1 төрөл	7,800
8.1.35	Сорил монгол 1 төрөл	4,300
8.1.36	Хумс аппаратаар эмчлэх (1 хумс)	10,000
8.1.37	Сийвэн эмчилгээ 1 удаа (Аутоплазм эмчилгээ)	15,000
8.1.38	Цус шүүх эмчилгээ хагас автомат 1 удаа (Плазмферез эмчилгээ)	30,000
8.1.39	Цус шүүх эмчилгээ бүрэн автомат 1 удаа (Плазмферез аппаратаар)	47,000
8.1.40	Халдварт нялаахайг гараар түүх 1 ширхэг	3,000
8.1.41	Хүзүүний тунгалагийн булчирхайн эдийн шинжилгээ авах	50,000
8.1.42	Эрүүг шилбэний ясаар орлуулах	1,200,000
8.1.43	Хүзүүний гилжгий засах	600,000
8.2	Нөхөн сэргээх мэс заслын тусламж, үйлчилгээ	
8.2.1	Хярзан нөхөн сэргээх мэс засал (TOT-transobturator tape хэрэглээгүй)	400,000
8.2.2	Хярзан нөхөн сэргээх мэс засал (TOT-transobturator tape хэрэглэсэн)	1,300,000
8.2.3	Шаамий засах эрүүний ясны мэс засал	8,000,000
9	Эмчийн үзлэг	
9.1	Эмчийн үзлэг	20,000
9.2	Ахлах, тэргүүлэх болон клиникийн профессор эмчийн үзлэг	25,000
9.3	Гавьяат эмч, АУ-ын доктор, зөвлөх эмчийн үзлэг	35,000
10	Сувилахуйн тусламж, үйлчилгээ	
10.1	Ходоод угаах	7,300
10.2	Цөс угаах	1,700
10.3	Клизм тавих	2,500
10.4	Дуслаар тариа хийх	1,700
10.5	Судсанд тариа хийх	1,000
10.6	Булчинд тариа хийх	1,000
10.7	Арьсан дор тариа хийх	900
10.8	Цэвэрлэх бургуй	5,200
10.9	Эмчилгээний бургуй	4,300
10.10	Хэт ягаан туяагаар цус шарж цэвэршүүлэх (УФОК цус шарах)	15,000
10.11	Судсанд гуурс тавих	5,300
10.12	Эгэмний доод венд гуурс тавих	35,000
10.13	Давсаг угаах	10,000
10.14	Шээс авах	5,000
10.15	Төмсөгний ус авах	20,000
10.16	Үтрээнд цацлага хийх	3,000
10.17	Боолт хийх 1 удаагийн (цэвэр, бохир)	3,000
11	Амбулатороор хийгдэх эмчилгээ	

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт	Жишиг хэмжээ /төгрөгөөр/
11.1	Хатаах тариа хийх (шамбарамд)	85,000
11.2	Шамбарам резин цагирагаар боох	140,000
11.3	Хэт улаан туяагаар шамбарам шарах	180,000
11.4	Салстад тариа хийх	25,000
11.5	Нүдний алимны зөөлөн эдэд тариа (холимог) хийх (Парабульбар смесь тарих)	8,500
11.6	Нүдний алимны араар (Ретробульбар) тариа хийх	8,000
11.7	Эвэрлэг, салстаас гадны биет авах	25,000
11.8	Нулимсны зам сэтгүүрдэж угаах	20,000
11.9	Өвдөг нээх	35,000
11.10	Халазион нээх	35,000
11.11	Зовхинд массаж хийх	15,000
11.12	Торлогийн лазер хийх	75,000
11.13	Хатиг, арьсан дорхи буглаа нээх	22,000
11.14	Шарханд анхдагч, хоёрдогч цэгцлэлт хийх	22,000
11.15	Сорви авах (1см)	22,000
11.16	Гигром, атром авах	23,000
11.17	Арьсан доорхи, хумсан доорхи ясанд орсон хэлбэрийн үед нээлт хийх	23,000
11.18	Хэвлий, цээжний хөндийд хатгалт (пункци) хийх	23,000
11.19	Асцитын үед хэвлийн хөндийн шингэн авах	23,000
11.20	Өөхөн хавдар авах (5 см хүртэл)	23,000
11.21	Өөхөн хавдар авах (5 см дээш)	30,000
11.22	Хурууны 1-2 үе тайрах	30,000
11.23	Идээлсэн атром авах	31,000
11.24	Суганы булчирхай авах	31,000
11.25	Спираль тавих (наркологи эмчийн заалттай тохиолдолд)	31,000
11.26	Нүдгүй (Анофтальмын) үед хийх суулгац (имплант) суулгах	200,000
11.27	Зовхины буулт (Птоз)-ын хагалгаанд хэрэглэгдэх суулгац (имплант) суулгах	270,000
11.28	Нулимсны суваг сэргээх имплант суулгах	500,000
11.29	Толгойны өвдөлт намдаах мигрени эмийн эмчилгээ	30,000
11.30	Толгойны өвдөлт намдаах мигрени ботулизм токсин эмчилгээ	200,000
11.31	Тархины цус харвалтын дараах өвдөлт намдаах эмчилгээ	30,000
11.32	Гурвалсан мэдрэлийн өвдөлт намдаах эмийн эмчилгээ	30,000
11.33	Гурвалсан мэдрэлийн өвдөлт эмийн эмчилгээний хориг хийх	50,000
11.34	Хүзүү орчмын нийлмэл өвдөлт намдаах хориг тавих (Stellate ganglion)	40,000
11.35	Хүзүүний булчингийн өвдөлт намдаах (Trigger point injection)	40,000
11.36	Гар дагасан дал мөрний өвдөлт намдаах хориг тавих (Suprascapular)	50,000
11.37	Хүзүү сээрний орчмын өвдөлт намдаах хориг тавих (Nerve root)	90,000
11.38	Хүзүү сээр орчмын тарилга хийх (Epidural steroid injection)	50,000
11.39	Рентген хяналтан дор нурууны өвдөлт намдаах хориг тавих (Nerve root)	90,000
11.40	Сүүжний ясны өвдөлт намдаах хориг тавих (sacroiliac joint)	70,000
11.41	Сээр, нуруу, хүзүүний хориг тавих (Facet blocks)	50,000
11.42	Өвдөгний өвдөлт намдаах эмчилгээ	40,000
11.43	Шагайны өвдөлт намдаах эмчилгээ	30,000
11.44	Хэвлийн өвдөлт намдаах эмчилгээ	40,000
11.45	Ташаа цавины өвдөлт намдаах эмчилгээ	40,000
11.46	Ууцны хориг хийх	20,000
11.47	Нуруу, нугас орчмын хориг хийх (Эпидурал)	50,000
11.48	Шодойн хориг хийх	40,000

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт		Жишиг хэмжээ /төгрөгөөр/
11.49		Хавирга хоорондын хориг хийх	30,000
11.50		ТАФ хориг хийх	50,000
11.51		Ганглион хориг хийх	60,000
11.52		Могойн яр бүх төрлийн өвдөлт намдаах	40,000
12	Стрессийн шалтгаант мэдрэлийн ядаргаа, нойргүйдэл зэрэг эмгэгийн оношилгоо, эмчилгээ		Тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
13	Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын тусламж үйлчилгээ		
13.1	Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө (1 удаа 60 мин)		10,000
13.2	Ганцаарчилсан сэтгэл засал эмчилгээ (1 удаа 90 мин хүртэл)		17,000
13.3	Гэр бүлийн сэтгэл засал (1 удаа 90 мин)		15,000
13.4	Хосын сэтгэл засал (1 удаа 90 мин)		20,000
14	Сэтгэл зүйн оношилгоо		
14.1	Танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн, харилцаа тодорхойлох сорил		25,000
14.2	Оюуны түвшин (IQ) тогтоох сорил		20,000
14.3	Бие хүн тодорхойлох сорил		20,000
14.4	Эмнэлзүйн сэтгэл судлалын шинжилгээ		20,000
14.5	Өөрийгөө удирдах эмчилгээний дасгал (1удаа)		5,000
14.6	Секспатологич эмчийн үзлэг		10,000
14.7	Түрүү булчирхайн массаж (1 удаа)		20,000
14.8	Оюуны ачаалал, ойлгох чадварыг тодорхойлох сорил		15,000
14.9	Сэтгэцийн үйл ажиллагааны багц сорил		20,000
14.10	Хүүхдийн авьяас, мэргэжил тодорхойлох сорил		20,000
15	Шүүх, сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ		
15.1	Шүүх, сэтгэцийн эмгэг судлалын дүгнэлт гаргах (анх удаа)		55,000
15.2	Шүүх, сэтгэцийн эмгэг судлалын дүгнэлт гаргах (давтан)		75,000
15.3	Полиграфийн шинжилгээ, дүгнэлт		40,000
16	Эрүүл мэндийн дүгнэлт гаргах		
16.1	Эрүүл мэндийн дүгнэлт гаргах (оношилгоо, шинжилгээ ороогүй)	Жолооны үнэмлэх авах	20,000
16.2		Гэр бүл болох, ажил сургуульд орох	20,000
16.3		Гадаад явах	30,000
17	Жирэмсний эрт үеийн үр хөндөлт (12 долоо хоног хүртэлх) /эмнэлгийн заалтаар хийх үр хөндөлт хамаарахгүй/		
17.1	Эмийн аргаар үр хөндөх		50,000
17.2	Гар соруурын аргаар ажилбар хийх (унтуулгагүй)		75,000
17.3	Гар соруурын аргаар ажилбар хийх (унтуулгатай)		95,000
18	Үргүйдлийн тусламж, үйлчилгээ		
18.1	Оношилгоо	Үрийн шингэний ерөнхий шинжилгээ	45,000
18.2		Үрийн шингэний дэлгэрэнгүй шинжилгээ	60,000
18.3		Эр үрийн шингэний шинжилгээ	15,000
18.4		Чанд авиан шинжилгээ (анх удаа)	18,000
18.5		Чанд авиан шинжилгээ (давтан)	10,000
18.6		Чанд авиан шинжилгээ (төмсөг, төмсөгний дайвар, түрүү булчирхай, үрийн цулцан)	21,000
18.7	Эмчилгээ	Үр цацах эмчилгээ (өндгөвч сэдээхгүй үед)	150,000
18.8		Үр цацах эмчилгээ (кломифен цитратаар өндгөвч сэдээх үед)	360,000
18.9		Зохиомлоор үр тогтоох эмчилгээ (Шар биеийн дааврыг саатуулах өндгөвч сэдээх бол)	6,600,000
18.10		Зохиомлоор үр тогтоох эмчилгээ (Шар биеийн дааврыг дэмжих өндгөвч сэдээх бол)	5,454,000

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт		Жишиг хэмжээ /төгрөгөөр/
18.11		Зохиомлоор үр тогтоох эмчилгээ (Урт хугацаанд өндгөвч сэдээх бол)	6,880,000
18.12		Өндгөн эсэд эр бэлгийн эс тарьж үр тогтоох	6,800,000
18.13	Бэлгийн эс, төмсөг, өндгөвчний эд хөлдөөх		40,000
18.14	Үрийн шингэнд эр эс байхгүй үед төмсгөнд оношилгоо эмчилгээний зорилгоор хатгалт хийх (PESA)		350,000
18.15	Үрийн шингэнд эр эс байхгүй үед төмсгөнд оношилгоо эмчилгээний зорилгоор төмсөгний эдийг авах (TESE)		450,000
19	Зайн оношилгоо		
19.1		Зайн зүрхний бичлэг	5,000
19.2		Зайн тархины бичлэг	30,000
19.3	Зайн оношилгоо (нэг удаагийн)	Зайн спирограмм	16,000
19.4		Зайн сахар оношилгоо	10,000
19.5		Зайн хэт авиан оношилгоо	20,000
19.6		Зайн рентген	9,000
19.7		Зайн зөвлөгөө (нэг удаагийн)	15,000
20	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс бусад эрүүл мэндийн байгууллагаас гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ		
20.1	Гэрийн асаргаа сувилгаа	Бүх биеийн угаалга	10,000
20.2		Толгой угаалга	2,000
20.3		Хэсэгчилсэн угаалга	4,000
20.4		Амны хөндийн арчилгаа	3,500
20.5		Цагаан хэрэглэл солих	1,500
20.6		Нуралт, холголт, цооролтоос урьдчилан сэргийлэх сувилахуйн тусламж	6,500
20.7		Хэвтрийн өвчтөнийг хооллох (гуурсаар)	6,500
20.8		Өвчтөн амирлах үед сувилгаа хийх, гэр бүлийн гишүүдийн сэтгэл санааг дэмжих	8,500
20.9		Хүнд өвчтөний асаргаа сувилгааны талаар гэр бүлийнхэнд сургалт явуулах (1цаг)	8,500
20.10		Колостомийн сувилгаа хийж өгөх (Бүдүүн гэдсэнд гуурс тавьж цэвэрлэх)	7,500
20.11		Трахеостомийн сувилгаа (Цагаан мөгөөрсөн хоолойн гуурс цэвэрлэх, солих)	7,500
20.12		Хагас суугаа байрлалд оруулж өгөх	3,000
20.13		Дасгал хөдөлгөөн заах	5,000
20.14		Хүнд болон хэвтрийн өвчтөнийг гэрт асарч сахихад	
20.15		1 цагт	10,000
20.16		8 цагт	40,000
20.17		24 цагт	80,000
20.18		Хүнд болон хэвтрийн өвчтөнийг эмнэлэгт асарч сахихад	
20.19		1 цагт	5,000
20.20		8 цагт	25,000
20.21		24 цагт	60,000
20.22		Химийн тариа хийх (2 цаг)	14,500
20.23		Химийн тариа хийх (24 цагаар)	50,000
20.24		Ходоод хаймсуурдах, угаах (эмчтэй хамт)	20,000
21	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэггүй эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх зарим оношилгоо, шинжилгээ, тусламж, үйлчилгээ		
21.1	Иммуногематологийн шинжилгээ		
21.1.1	Эргэлзээтэй цусны бүлэг тодорхойлж баталгаажуулах		15,000
21.1.2	Цусны ABO, резус бүлэг тодорхойлох		2,000
21.1.3	Цусны резус бүлэг баталгаажуулах		5,000
21.1.4	Хувийн тохироо тодорхойлох		10,000
21.1.5	anti-A титр тодорхойлох		6,500
21.1.6	Улаан эсийн эсрэг бие илрүүлэх		26,000
21.1.7	Улаан эсийн эсрэг бие ялган дүйх		26,000
21.1.8	Кумбсын шууд болон шууд бус урвалын шинжилгээ хийх (тус тусдаа)		23,000

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт	Жишиг хэмжээ /төгрөгөөр/	
21.2	Эд, эсийн шинжилгээ		
21.2.1	Эд, эсийн шинжилгээ авах (задлах эсийн наац /зүүгээр, түрхэцийн/, биопси /эд/ авах, нээлттэй, зүүгээр/)	11,500	
21.2.2	Эсийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх	20,000	
21.2.3	Нарийн зүүний хатгалтын шинжилгээ хийх (FNA)	40,000	
21.2.4	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх /зөөлөн эд, бүх төрлийн дурангаар авсан эд/	23,000	
21.2.5	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (ясны эд)	30,000	
21.2.6	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (мэс ажилбараар авсан эд)	33,000	
21.2.7	Ясны хэмийн эсийн шинжилгээ авах, лабораторит шинжлэх (эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ороогүй)	50,000	
21.2.8	Ясны хэмийн эдийн шинжилгээ авах, лабораторит шинжлэх (эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ороогүй)	80,000	
21.2.9	Хувийн эрүүл мэндийн байгууллагын хүсэлтээр хийх эмгэг судлалын задлан шинжилгээ хийх	53,000	
21.2.10	Иммуногистохимийн шинжилгээ хийх (маркерийн тооноос шалтгаална)	150,000	
21.2.11	Арьсны эдийн шинжилгээ авах, шууд дархан туяарах будгийн аргаар эдийг бэлтгэх, онош дүгнэлт өгөх	60,000	
21.2.12	Шууд бус дархан туяарах будгийн аргаар эдийг бэлтгэх, онош дүгнэлт өгөх	45,000	
21.2.13	Арьсны аутоиммун цэврүүт өвчнүүдийг ялган оношлох бүрдэл шинжилгээ хийх (Дерматологийн мозайк)	270,000	
21.2.14	Арьсны хавдар болон бусад өвчнүүдийн ялган оношлох иммуногистохимийн будгийн арга (үзүүлэлт тус бүр)	100,000	
21.2.15	Арьсны бүтцийн уургуудийг эсрэг ауто эсрэг бие илрүүлэх шинжилгээ хийх	100,000	
21.2.16	Хачиг илрүүлэх шинжилгээ хийх (Демодекс)	9,000	
21.2.17	Мөөгөнцөрийн үүсгэгчийг микроскопоор харах	9,000	
21.2.18	Мөөгөнцөрийн өсгөврийг тэжээлт орчинд ургуулах	15,000	
21.2.19	Мөөгөнцөр ургуулах	10,000	
22	Орчин хүнстэй холбогдох шинжилгээ		
22.1	Ундны усанд физик химийн үзүүлэлтүүд үзэх	12,000	
22.2	Ундны усанд хийх шинжилгээ	Ундны усанд Катион тодорхойлох	10,500
22.3		Ундны усанд Анион тодорхойлох	20,600
22.4	Бохир усанд хийгдэх шинжилгээ	Мэдрэхүйн шинжилгээ хийх	2,200
22.5		Бохир усанд физик химийн үзүүлэлтүүд үзэх	33,600
22.6	Бохир усанд хийгдэх шинжилгээ	Бохир усанд Катион тодорхойлох	9,500
22.7		Бохир усанд Анион тодорхойлох	22,800
22.8		Бохир усанд Мэдрэхүйн шинжилгээ хийх	3,000
22.9		Орчны агаарт хүхэрлэг хий тодорхойлох (SO ₂)	35,000
22.10	Орчны агаарын шинжилгээ	Орчны агаарт азотын давхар исэл тодорхойлох (NO ₂)	7,000
22.11		Орчны агаарт нүүрстөрөгчийн дутуу исэл тодорхойлох (SO ₂)	7,000
22.12		Орчны агаарт тоосны хэмжээ тодорхойлох (PM-2.5)	7,000
22.13		Нянгийн нийт тоо тодорхойлох	8,500
22.14	Микробиологийн лабопатопит хийх	E.coli тоо тодорхойлох	8,500
22.15		Энтерококк тодорхойлох	5,500
22.16		Цус задлагч нян тодорхойлох	6,500
22.17		Хөгц мөөгөнцөр тодорхойлох	6,000
22.18		Эмгэг төрөгч нян тодорхойлох	6,500
22.19		Агааргүйтэн нян тодорхойлох	6,000
22.20		Протеус тодорхойлох	5,500
22.21		Арчдас авах	500

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт		Жишиг хэмжээ /төгрөгөөр/
22.22	шинжилгээ	Стафилококк тодорхойлох	7,500
22.23		V810 Ундны уснаас хүхэрт устөрөгч илрүүлэх оношлуур (шилтэй)	2,500
22.24		V810 Ундны уснаас хүхэрт устөрөгч илрүүлэх оношлуур (шилгүй)	1,500
22.25		V111 Ундны усны колиформ нянг илрүүлэх оношлуур (шилтэй)	2,500
22.26		V111 Ундны усны колиформ нянг илрүүлэх оношлуур (шилгүй)	1,500
22.27		SI Арчдасны шинжилгээний оношлуур (шилтэй)	2,500
22.28		SI Арчдасны шинжилгээний оношлуур (шилгүй)	1,500
23		Шим тэжээлийн лабораторт хийх шинжилгээ	
23.1	Хоолны дээж	Хоолны дээжний ерөнхий шинжилгээ	18,000
23.2		C аминдэм тодорхойлох	5,000
23.3		Төмөр тодорхойлох	5,000
23.4		Кальци тодорхойлох	5,000
23.5		Магни тодорхойлох	5,000
23.6		Фосфор тодорхойлох	5,000
23.7		Ерөнхий хүчиллэг тодорхойлох	3,500
23.8		Хоолны давс тодорхойлох	4,000
23.9	Гурил	Гуриланд чийг тодорхойлох	4,500
23.10		Ерөнхий эрдэс тодорхойлох	5,500
23.11		Өөх тос тодорхойлох	5,000
23.12		Нүүрс ус тодорхойлох	5,000
23.13		Уургийн бодистодорхойлох	6,000
23.14		Цавуулаг тодорхойлох	3,000
23.15		Цардуул тодорхойлох	4,000
23.16		Хүчиллэг тодорхойлох	2,500
23.17	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Исгэлэн чанар тодорхойлох	3,000
23.18		Сүүний нягт тодорхойлох	3,000
23.19		Сүү цагаан идээний чийг хуурай бодис тодорхойлох	4,000
23.20		Тослог тодорхойлох	5,000
23.21		Нийт уураг тодорхойлох	5,000
23.22	Хиам, Мах махан бүтээгдэхүүн	Чийг тодорхойлох	4,000
23.23		Үнслэг тодорхойлох	5,000
23.24		Чөлөөт тослог, өөх тосны хэмжээ тодорхойлох	5,000
23.25		Нитрит тодорхойлох	10,000
23.26		Азотын хэмжээ тодорхойлох	5,000
23.27		Шинэлэг байдал тодорхойлох	2,000
23.28		Ерөнхий эрдэс бодис тодорхойлох	5,000
23.29		Уургийн бодис тодорхойлох	5,000
23.30		Давсны хэмжээ тодорхойлох	5,000
23.31		Ундаа	Ундааны мэдрэхүйн үзүүлэлт
23.32	Хуурай бодис тодорхойлох		2,500
23.33	Чихэрлэгийн хэмжээ тодорхойлох		5,000
23.34	Хүчиллэг тодорхойлох		3,500
23.35	Тогтворжилт тодорхойлох		1,500
23.36	Витамин С тодорхойлох		5,000
23.37	Тунгалагшилт тодорхойлох		2,500
23.38	Уураг тодорхойлох		5,000
23.39	Талх чихэр, гурилан бүтээгдэхүүн	Чийг тодорхойлох	4,000
23.40		Хүчиллэг тодорхойлох	3,500
23.41		Сийрэгжилт тодорхойлох	2,500
23.42		Тослог тодорхойлох	5,000
23.43		Чихэрлэгийн хэмжээ тодорхойлох	5,000
23.44		Давсны хэмжээ тодорхойлох	2,500
23.45		Уураг тодорхойлох	5,000
23.46		Тунгалагшилт тодорхойлох	2,800

№	Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт		Жишиг хэмжээ /төгрөгөөр/
23.47		Хүчиллэг тодорхойлох	7,200
23.48	Хүнсний тос	Давсны хэмжээ тодорхойлох	5,000
23.49		Ханаагүй хүчлийн хэмжээ тодорхойлох	7,500
23.50		Шинэлэг байдлын хэмжээ тодорхойлох	7,500
23.51		Цэвэршилт тодорхойлох	2,000
23.52	Элсэн чихэр	Чийг тодорхойлох	4,000
23.53		Сахарозын хэмжээ тодорхойлох	9,000
23.54		Хуурай бодисын хэмжээ тодорхойлох	4,000
23.55	Хүнсний ногоо	Эрдэс бодисын хэмжээ тодорхойлох	5,000
23.56		Нитрат тодорхойлох	10,000
23.57		РН тодорхойлох	1,000
23.58		С амин дэм тодорхойлох	5,000
23.59		Дээжний задаргаа хийх	3,500
23.60	Атом шингээлтийн спектрометрийн шинжилгээ	Хар тугалга (Pb) тодорхойлох	7,500
23.61		Кадми (Cd) тодорхойлох	5,500
23.62		Хүнцэл (As) тодорхойлох	16,000
23.63		Төмөр (Fe) тодорхойлох	7,500
23.64		Зэс (Cu) тодорхойлох	8,000
23.65		Хром (Cr) тодорхойлох	8,000
23.66		Цайр (Zn) тодорхойлох	7,500
23.67		Манган (Mn) тодорхойлох	7,500
23.68		Кобальт(Co) тодорхойлох	7,500
23.69		Никель (Ni) тодорхойлох	7,500
23.70		Мөнгөн ус тодорхойлох	15,000

II. Нэмэлт тусламж, үйлчилгээний жишиг хэмжээ

№	Нэмэлт тусламж, үйлчилгээний жагсаалт	Жишиг хэмжээ /төгрөгөөр/
24	Нэмэлт тусламж, үйлчилгээ	
24.1	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ (энгийн)	20,000
24.2	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ (хагас люкс)	30,000
24.3	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ (люкс)	50,000
24.4	Захиалгат хоол	Тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
24.5	Захиалгат угаалга	Тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
24.6	Захиалгат тээвэр	Тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
24.7	Үйлчлүүлэгчийн хүсэлтээр үзүүлэх бусад нэмэлт тусламж, үйлчилгээ	Тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
25	Шарил хадгалах үйлчилгээ	
25.1	Шарил хадгалах үйлчилгээ /нэг хоногт, эмнэлгийн нас баралтаас бусад/	20,000



“Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмыг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллага /цаашид эрүүл мэндийн байгууллага гэх/-аас үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй, эсвэл эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ авах зардлын төлбөр нь тухайн улирлын болон жилийн дээд хязгаараас хэтэрсэн иргэнд нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлснээс бий болсон орлогыг зарцуулахад загвар болгон ашиглана.

1.2 Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчид үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний өртөг, зардлыг тооцсоны үндсэн дээр тухайн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан жишиг хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тогтооно.

1.3 Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ нь тухайн тусламж, үйлчилгээг үзүүлж буй эрүүл мэндийн ажилтны цалин хөлс нийгмийн даатгалын шимтгэл, эм, зарим эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн элэгдэл, урвалж бодисын өртгөөс бүрдэнэ.

Хоёр. Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээнээс олсон орлогын бүртгэл, зарцуулалт

2.1 Эрүүл мэндийн байгууллага нь нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого, зарцуулалтыг бодитой төлөвлөж, жил бүрийн төсөвтөө тусгана.

2.2 Тухайн жилийн төсөвт тусгагдаагүй, шинээр үүссэн нөхцөл байдлын улмаас бий болсон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг Сангийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 216 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журмаар зохицуулна.

2.3 Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээнээс олсон орлого нь тухайн эрүүл мэндийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогод бүртгэгдэнэ.

2.4 Эрүүл мэндийн байгууллага нь нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг хураах үйл ажиллагааг нэг цэгт төвлөрүүлэн зохион байгуулна.

2.5 Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээнээс олсон орлогыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэн, төрийн сан дахь төсвийн харилцах дансанд төвлөрүүлнэ.

2.6 Эрүүл мэндийн байгууллага нь иргэнд төлбөр төлсөн баримтыг заавал олгох бөгөөд уг баримтад эрүүл мэндийн байгууллагын нэр, үйлчлүүлэгчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

2.7 Эрүүл мэндийн байгууллага нь нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотойг гарч байгаа шууд зардал болон байгууллагын ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна. Үйлчилгээ үзүүлэхэд гарах шууд зардалд дараахь зардлууд хамаарна:

2.7.1. эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал;

2.7.2. үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн ажилтны цалин;

2.7.3. багаж, тоног төхөөрөмж худалдан авах болон тэдгээрийн засвар үйлчилгээний зардал.

2.8 Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг эхний ээлжид энэ журмын 2.7.1, 2.7.2-т заасан зардлыг санхүүжүүлж, үлдэх хэсгийг эмнэлгийн багаж тоног төхөөрөмж худалдан авах болон эмнэлгийн ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна.

2.9 Эрүүл мэндийн байгууллагын удирдлага нь энэхүү тушаалын 2.7 дахь заалтад заасан үйл ажиллагааны зардлыг зарцуулах нарийвчилсан журмыг батлан мөрдүүлж болно.

Гурав. Хориглох зүйл

3.1 Эмч, эмнэлгийн ажилтанд дараахь зүйлсийг хориглоно:

3.1.1 энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан төлбөрийн жишиг хэмжээнээс хэтэрсэн төлбөр нэхэмжлэх;

3.1.2 эрүүл мэндийн байгууллагын ажлын үндсэн цагт багтаан үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхээр үйлчлүүлэгчийг ятгах;

3.1.3 үйлчлүүлэгчээс үйлчилгээний төлбөр хураан авах.

Дөрөв. Хяналт

4.1 Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй байх чиглэлээр төлбөрт үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар хүлээнэ.

4.2 Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл болон төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд эрүүл мэндийн байгууллагын дотоод аудитын нэгж улирал бүр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дотоод аудитын нэгж жилд нэг удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана.

4.3 Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал, төлбөрт үйлчилгээний орлогын зарцуулалтын талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг байгууллагын дарга, захирал нар хангаж ажиллана.

Тав. Хариуцлага

5.1 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, эмч, эрүүл мэндийн ажилтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

-----oO-----

Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын
2017 оны 284/203... тоот тушаалын
гуравдугаар хэсэрт

**“Нэмэлт тусламж,
үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэх журам”**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журмаар төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллага /цаашид эрүүл мэндийн байгууллага гэх/ эрүүл мэндийн нэмэлт тусламж, үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Дараахь тусламж, үйлчилгээ хамаарна:

- 1.2.1. эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ;
- 1.2.2. захиалгат хоол, угаалга, тээвэрлэлт;
- 1.2.3. шарил хадгалах;
- 1.2.4. үйлчлүүлэгчийн хүсэлтээр үзүүлэх бусад нэмэлт тусламж, үйлчилгээ.

Хоёр. Төлбөр төлөх

2.1. Иргэн нэмэлт тусламж, үйлчилгээний төлбөрийг зөвхөн төлбөр хураах төвлөрсөн цэгт төлж, төлбөр төлснийг нотлох баримт авна. Үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн ажилтан үйлчлүүлэгчээс биечлэн төлбөр авахыг хориглоно.

2.2. Эрүүл мэндийн байгууллага нь иргэнд төлбөр төлсөн баримтыг заавал олгох бөгөөд уг баримтад эрүүл мэндийн байгууллагын нэр, үйлчлүүлэгчид нэмэлтээр үзүүлсэн үйлчилгээний нэр, төрөл, төлбөл зохих нийт болон нэмэлтээр авсан үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

2.3. Иргэн өөрийн хүсэлтээр нэмэлт тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргавал тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртэлх үеийн төлбөрийг тооцож, үлдэгдэл төлбөрийг ямар нэгэн шимтгэл, алдангигүйгээр буцаан олгож баримтжуулна.

Гурав. Бусад

3.1. Иргэн эрүүл мэндийн байгууллагын нэмэлт тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргах эрхтэй.

3.2. Эрүүл мэндийн байгууллага энэхүү тушаалыг зөрчиж, төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулна.